



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А006

Улаанбаатар хот

Дүрэм, бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.16 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/137 дугаар тушаалаар батлагдсан Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн дүрэм, бүтцийн 4.4 дэх хэсэг, Төвийн дотоод журмын 5.3.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн дүрмийг нэгдүгээр, Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Уг тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны албаны дарга /Н.Янжиндулам/-д даалгасугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирлын 2013 оны а/44 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ




Н.ЭРДЭНЭБАЯР

Tushaal.2018.doc

080144

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2018 оны
01 дугаар сарын 01-ний өдрийн
406 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү дүрмийн зорилго нь Цус сэлбэлт судлалын үндэсний төв (цаашид “Төв” гэх)-ийн Эрдмийн зөвлөлийн (цаашид “Эрдмийн зөвлөл” гэх) үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Эрдмийн зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн шийдвэр болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг удирдлага болгоно.
- 1.3 Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/137 дугаар тушаалаар батлагдсан Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн дүрмийн 4.4 дэх заалтад “Төв нь эрдэм, шинжилгээний ажлын тэргүүлэх чиглэл, ойрын болон хэтийн зорилтыг тодорхойлох, судалгаа шинжилгээний сэдэв, арга зүй, явц, үр дүнг хэлэлцэн тэдгээрт үнэлэлт, дүгнэлт гаргах, цус сэлбэлтийн шинжлэх ухааны чиглэлээр эрдэм судлалын ажлыг үндэсний хэмжээнд зохицуулах Эрдмийн зөвлөлтэй байна. Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг төвийн Ерөнхий захирал батлана.” гэж тусгасан байна.

Хоёр. Эрдмийн зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

- 2.1 Эрдмийн зөвлөл нь Эрдмийн зөвлөлийн дарга, Эрдэмтэн нарийн бичгийн дарга, гишүүд гэсэн нийт 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байх ба төвийн Ерөнхий захирал нь Эрдмийн зөвлөлийн дарга байж болно.
- 2.2 Эрдмийн зөвлөлийн гишүүд нь анагаах ухааны болон бусад салбарын доктор, шинжлэх ухааны докторын цол, зэрэгтэй байна.
- 2.3 Эрдмийн зөвлөл нь хүндэт гишүүнтэй байж болно. Хүндэт гишүүн нь таслах эрхгүй оролцоно.
- 2.4 Эрдмийн зөвлөлийн дарга, эрдэмтэн нарийн бичгийн дарга болон гишүүдийг чөлөөлөх, шинээр томилох, асуудлыг Удирдах зөвлөлөөс санал оруулж, төвийн захирал шийдвэрлэн, тушаал батална.
- 2.5 Эрдмийн зөвлөлийн даргын түр эзгүйд түүний албан үүргийг Эрдэмтэн нарийн бичгийн дарга орлоно.
- 2.6 Эрдмийн зөвлөл нь өөрийн албан хуудастай байна.
- 2.7 Эрдмийн зөвлөлийн албан хуудсыг ЦССҮТ-ийн тэмдгээр баталгаажуулна.

Гурав. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаа

- 3.1 Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Хурлыг тухайн үеийн шаардлагаар зарлан хуралдуулна.
- 3.2 Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг Эрдэмтэн нарийн бичгийн дарга эрхэлж, эцсийн шийдвэрийг хурлаар баталгаажуулна. Хурлыг эрдмийн зөвлөлийн дарга, даргын эзгүйд эрдэмтэн нарийн бичгийн дарга удирдана.
- 3.3 Төвийн эрдэм шинжилгээ, сургалт, инноваци, технологийн бодлого, чиглэлтэй холбоотой асуудлыг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт гаргах,
- 3.4 Төвийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тэргүүлэх чиглэл, ойрын болон хэтийн зорилтыг тодорхойлох,
- 3.5 Төвийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын жилийн тайлан болон эрдэмтэн, судлаачдын судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг хэлэлцэж, шийдвэр гаргах,
- 3.6 Төвийн эмч, мэргэжилтэн, эрдэмтэн, судлаачдын гүйцэтгэх сургалт, судалгааны (ШУТ-ийн төсөл, суурь судалгааны сэдэвт ажил, цөм болон инновацийн төсөл, гэрээгээр гүйцэтгэх туршилт судалгаа, зохион бүтээх ажил) төсөл, хөтөлбөрийг шалгаруулж дэвшүүлэх, шийдвэрлүүлэх.
- 3.7 ШУТ-н төсөл, цөм технологи, инновацийн төсөл, гэрээт ажлын хөтөлбөр, арга зүйг баталж, гүйцэтгэлд хяналт тавьж, судалгааны тайланг хэлэлцэх хамгаалуулах,
- 3.8 Төвийн эмч, мэргэжилтэн, эрдэмтэн, судлаачдын нэг сэдэвт зохиол, сурах бичиг, ном, товхимол, гарын авлага болон шинжлэх ухааны нээлт, шинэ бүтээл, патент зэргийг хэвлүүлэх, нийтлүүлэхэд санал оруулах, эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлыг хамтран зохион байгуулах,
- 3.9 Цусны албаны клиникийн профессорын цол, төрийн дээд одон медальд нэр дэвшигчдийг хэлэлцэх, дэвшүүлэх
- 3.10 Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаа, хурлыг зохион байгуулахтай холбогдох зардлыг эрдэм шинжилгээ болон сургалтын төсөвт тусгаж төвийн Удирдлагын зөвлөлийн шийдвэрээр олгоно.
- 3.11 Эрдмийн зөвлөлийн гишүүдэд хурлын ирц, хуралдсан хугацааг харгалзан цагийн 10000 төгрөгөөр тооцож, ажлын хөлс олгоно.

Дөрөв. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн эрх, үүрэг

4.1 Эрдмийн зөвлөлийн гишүүний эрх

- 4.1.1 Эрдмийн зөвлөлөөр асуудал хэлэлцүүлэх, хэлэлцэж байгаа асуудлыг хянах, комиссын бүрэлдэхүүнд ажиллах, үнэлэлт, дүгнэлт өгөх, Эрдмийн зөвлөлийн хуралтай холбоотой бичиг баримттай танилцах,
- 4.1.2 Эрдмийн зөвлөлийн гишүүн нь ажлын хэсэг, комисст сонгогдох,
- 4.1.3 Эрдмийн зөвлөлийн гишүүнээс татгалзах,

4.2 Эрдмийн зөвлөлийн гишүүний үүрэг

- 4.2.1 Эрдмийн зөвлөлийн хуралд биечлэн оролцох, санал өгөх,
- 4.2.2 Хүндэтгэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй бол Эрдмийн зөвлөлийн дарга эсвэл эрдэмтэн нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэх,
- 4.2.3 Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, бүх талаар дэмжлэг туслалцаа үзүүлэх,
- 4.2.4 Эрдмийн зөвлөлийн гишүүд албан ёсны хурлын тэмдэглэлийн дэвтэрт хурлын үйл ажиллагааны талаар тэмдэглэн хөтлөх,
- 4.2.5 Эрдэмтэн нарийн бичгийн дарга нь Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний төлөвлөгөөт ажлын явц, хэрэгжилтэд байнгын хяналт тавин ажиллаж, эрдмийн зөвлөлийн ажлын төлөвлөгөө, тайланг боловсруулан хэлэлцүүлэх, эрдмийн зөвлөлийн хурлын бэлтгэлийг хангах, хурлын шийдвэрийг зохицуулан хэрэгжүүлэх, шаардлагатай бол зохих шийдвэрийг гаргуулж байх үүргийг хүлээнэ.

Тав. Эрдмийн зөвлөлөөр асуудал хэлэлцүүлэхэд тавигдах шаардлага

- 5.1 Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэх асуудал нь анхан шатны нэгжийн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн хурлын тэмдэглэлтэй байна.
- 5.2 Асуудал хэлэлцүүлэгч нь уг асуудлынхаа талаар танилцуулга, шаардагдах бичиг баримт (салбар зөвлөл, мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн тухай тэмдэглэл гэх мэт)- ыг бүрдүүлж Эрдэмтэн нарийн бичгийн даргад хурлын товоос 7-оос доошгүй хоногийн өмнө ирүүлнэ.
- 5.3 Хэлэлцэх асуудлыг Эрдэмтэн нарийн бичгийн дарга хянаж, хурлын товыг Эрдмийн зөвлөлийн даргатай зөвшилцөн тогтоож, гишүүдэд 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 5.4 Хэлэлцүүлэгч уг асуудлаар танилцуулах материалыг 1-3 хуудсанд багтаан бусад холбогдох материалын хамт эрдмийн зөвлөлийн гишүүн тус бүрт хурлын товоос 3-5 хоногийн өмнө хүргэж, шаардлагатай нөхцөлд нэмэлт танилцуулга хийж болно.
- 5.5 Эрдмийн зөвлөлийн гишүүд нь хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцаж санал, дүгнэлтээ бэлтгэсэн байна.
- 5.6 Гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаантай хуралд оролцох боломжгүй бол Эрдмийн зөвлөлийн даргад мэдэгдэж, хэлэлцэх асуудлаар саналаа Эрдэмтэн нарийн бичгийн даргад бичгээр өгсөн нөхцөлд саналыг таслах эрхтэйд тооцно.

Зургаа. Эрдмийн зөвлөлийн хурлын дэг

- 6.1 Эрдмийн зөвлөлийн нэг удаагийн хурлаар 3-аас илүүгүй асуудал хэлэлцэнэ.
- 6.2 Эрдмийн зөвлөлийн гишүүдийн ирц 75 ба түүнээс дээш байвал хурал хүчин төгөлдөр байна.
- 6.3 Шаардлагатай тохиолдолд хэлэлцэж буй асуудлын чиглэлээр холбогдох мэргэжилтэн, эрдэмтдийг урьж оролцуулна.
- 6.4 Эрдмийн зөвлөлийн хурлын дараалал:

- Хурлын дарга хурлыг нээх
- Хэлэлцэх асуудлыг танилцуулах 10 минут (хэлэлцүүлэгч байлцаж болно)
- Танилцуулга болон санал дүгнэлттэй холбогдуулан Эрдмийн зөвлөлийн гишүүд асуулт асууж, хариулт авах (гишүүн тус бүр 5 минут)
- Хэлэлцүүлэг хийх хугацааг хурлын дарга тогтоох ба нэг гишүүний санал дүгнэлт хэлэх хугацаа 7 минутаас хэтрэхгүй байх
- Санал дүгнэлт сонсох
- Хурлын шийдвэр гаргах
- Дарга хурлыг хааж үг хэлэх

6.5 Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг гишүүдийн санал хураалтын дүнг үндэслэн гаргах ба гишүүд санал зөрөлдөөнтэй тохиолдолд ил ба нууц санал хурааж, олонхийн буюу 51%-иас дээш саналаар эцсийн шийдвэр гаргана.

6.6 Эрдмийн зөвлөл хэлэлцсэн асуудлаараа албан хуудсыг ашиглан тогтоол, тэмдэглэл гаргаж, Эрдмийн зөвлөлийн дарга, Эрдэмтэн нарийн бичгийн даргын гарын үсгээр баталгаажуулна.

6.7 Эрдэмтэн нарийн бичгийн дарга хурлын явц, гишүүдийн санал, дүгнэлт, эцсийн шийдвэрийн талаар хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөх ажлыг хариуцана.

6.8 Хурлын тэмдэглэлд дараах зүйлийг тусгасан байна:


- Хурал эхэлсэн, дууссан, асуудлыг хэлэлцсэн огноо, цаг хугацаа
- Ямар асуудлаар хэн хэлэлцүүлсэн, уг асуудалтай холбоотой асуулт, хариулт, санал, шүүмжлэл, хэлсэн үг
- Санал хураалтын дүн (тоо ба хувиар)

Долоо. Бусад

7.1 Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой маргаан, алдаа дутагдалтай асуудал, гомдол, саналыг Зөвлөлийн хурлаар, шаардлагатай үед төвийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

7.2 Бусад тохиолдолд холбогдох хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэнэ.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2018 оны
01 дугаар сарын 01-ний өдрийн
406 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүн

Эрдмийн зөвлөлийн дарга:

Н.Эрдэнэбаяр /АУ-ны доктор, дэд
профессор/

Эрдэмтэн нарийн бичгийн дарга:

Ж.Жамбалдорж /АУ-ны доктор/

Гишүүд:

Г.Даваа /АУ-ны доктор, профессор/

Д.Отгонбаяр /АУ-ны доктор, профессор/

Л.Баттөр /АУ-ны доктор/

Ц.Одгэрэл /АУ-ны доктор, дэд профессор/

Б.Дамдиндорж /АУ-ны доктор/

Л.Энхсайхан /АУ-ны доктор/

Б.Хишигжаргал /АУ-ны доктор/